



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/802

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл (Тэшиг сум)-ийг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Энх алтаргана” ХХК-тай 298,949,289 (хоёр зуун ерэн найман сая есөн зуун дөчин есөн мянга хоёр зуун наян ес) төгрөгөөр гэрээ байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Энх алтаргана” ХХК-ийн захирал (А.Энхжаргал)-д даалгасугай.

3. Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэж хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Тэшиг сумын Засаг дарга (Б.Гансүх)-д үүрэг болгосугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль журам, гэрээний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6324011197

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 26-ны/ний өдрийн 41802 дугаар
захирамжийн хавсралт

Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	5 190 993	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	5 190 993	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2 595 497	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
6	Баталгаат хугацаа	3 жил	Ү.Бямбасүрэн Б.Гансүх
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Д.Батцогт